

өнгөрүүлэхэд анхаарч төрөл бүрийн тэмцээн, уралдааныг сургууль, багш, эцэг, эх, хүүхдийн эрхийг хамгаалах. залуучуудын хөгжлийн төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын хамтын оролцоотойгоор зохион явуулах ажлыг хэвшүүлэх;

Г.Бямбасайхан -Хууль сахиулахын их сургууль, Хууль сахиулах удирдлагын академийн 8032 дугаар дамжааны суралцагч.цагдаагийн хошууч

Ю.Бадамханд -ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн Цагдаагийнудирдлага. стратегийн профессорын багийн дэд профессор. хууль зүйн доктор (Ph.D). цагдаагийн хурандаа

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ БА МОНГОЛ УЛС ДАХЬ МӨНГӨ ХҮҮЛЭЛТБҮЮУ “ХОНОГИЙН ЗЭЭЛ”-ИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хураангуй: Мөнгө угаах гэмт хэрэг нь байршуулах, тараах буюу гүйлгээнд оруулах, буцааж төвлөрүүлэх гэсэн 3 үе шаттайгаар хийгддэг. Эхний үе шат буюу байршуулах үе шатанд хууль бусаар олсон мөнгөө хаа нэгтээ байршуулах шаардлагатай байдаг. Тухайлбал гэмт этгээд өөр хүний нэр дээр нээлгэсэн дансанд хууль бусаар олсон мөнгөө анхаарал татахааргүй хэмжээтэйгээр таслан хийх, үнэт цаас, чек, хувьцаа худалдан авах, эсхүл байр, байшин ч худалдан авах замаар байршуулж болно. Хоёр дахь үе шатанд гарал үүслийг нь нуун далдлах, хууль ёсны орлого мэт харагдуулах зорилготойгоор нэгэнт байршуулсан мөнгөө Нэг өдрийн” буюу “хоногийн” зээл гэх санхүүгийн харилцаанд эргэлтэнд оруулж мөнгө хүүлэх аргаар ашиг орлого олж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Манай улсад эдийн засгийн гэмт явдлын хамаарал буюу сул хяналтгүй мөнгөний урсгал болох мөнгө угаах гэмт хэргийн объектив шинжийг агуулсан илрэн гарах нэг хэлбэр нь байж болох мөнгө хүүлэлтийн эсрэг тэмцэх цогц арга хэмжээг төрөөс авах ёстой. Өөрөөр хэлбэл энэ төрлийн харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага тулгараад байна. Хууль эрх зүйн орчноо сайжруулахгүй бол тухайн төрлийн буюу мөнгө хүүлэлттэй тэмцэж чадахгүй гэсэн дүгнэлтэд хүрч байгаа талаар илтгэлдээ дурдсан.

Түлхүүр үг: Мөнгө угаах, мөнгө хүүлэлт,хууль эрх зүй, харилцан хамаарал.

Нэг. Удиртгал

Мөнгө бол нийгмийн бүхий л харилцааны асуудлуудыг зохицуулахаас гадна хувь хүний мөн чанарыг нээж өгдөг илрүүлэгч гэдэгтэй олон хүн санал нийлнэ гэдэгт итгэлтэй байна. Хүний хүн чанарыг танихын тулд магадгүй цорын ганц зүйл дээр, тухайлбал мөнгөн дээр суурилан судлахад бараг л буруудахгүй байх.

Мөнгөнөөс болж хүн гаргадаггүй аашийг гаргаж, хүний энэ богинохон хорвоод багтах шингэхгүй болтлоо цадиггүй төрхийг үзүүлж зарим нь таван цаасны хуримтлалтай болмогцоо хүн төрлөөс ангижраад дээд төрлийг олчихсон юм шиг эргэн тойрныхондоо хүн бус харилцааг үзүүлдэг байна. Өөрөөр хэлбэл зарим нь мөнгийг ертөнцийн цорын ганц хаан хэмээн сохроор итгэн хамгийн үнэтэй бүхнээ уландaa гишгэн мөнгөний төлөө үхэн хатан зүтгэсээр насыг элээдэг.

Энэ мэт мөнгийг тойрсон хүний мөн чанартай холбоотой олон зүйлүүд аяндаа л бий болдог. Гэхдээ мөнгө муу муухай бүхний жишээ биш юм. Мөнгөтэй хүмүүс бүгдээрээ муу муухай амьтад байдаг гэдэг бол ихээхэн гажуудсан, эрүүл бус ойлголт юм. Тэр бүү хэл мөнгөөр дамжин илрэх сайхан сэтгэл аль байдгийг тэр гэхэв. Хамгийн хүнд үед сэтгэлээсээ туслах гээд таван төгрөг дугтуйлаад ирж байгаа найз нөхдөө бид хүндлэх ёстой. Хүндлээд зогсохгүй сайн хүн юм байна гэдэгт нь насан туршдаа итгэж явах хэрэгтэй гэж би хувьдаа боддог юм.

Харин мөнгөнөөс болж хүнээ байсан нөхдүүдтэй эргээд хүний ёсоор итгэж харьцана гэдэг бол туйлын тэнэг явдал болох байх. Өөрөөр хэлбэл мөнгө хүмүүсийг хэн нь хэн бэ гэдгийг тод томруунаар хэлээд өгчихдөг юм. Тийм болохоор мөнгийг олж байгаа хүнийг хараах биш, мөнгөнд хандаж байгаа хүний хандлагыг таних нь туйлын чухал юм. Нөгөө талаас мөнгө хэмээгч бодитой хэрнээ хийсвэр, бараг л хий үзэгдэл шахуу зүйлийг нийгмийн сүнс хэмээн нэрийдэхэд ч буруудахгүй болжээ.

Тиймээс тухайн нийгэмд мөнгө хэр зэрэг зөв эргэлттэй байна, тэр хэмжээгээр хөгжил дэвшил, аз жаргал, ирээдүй, соёл боловсрол, халамж, эрх зүйн хэрэгжилт гээд олон зүйлүүдийн утга учир. хэм хэмжээ тодорхойлогддог юм. Нийгэм нь мөнгөний зөв сайн эргэлттэй, ард иргэд нь тэрхүү мөнгөний эргэлтэнд чөлөөтэй оролцох боломжтой тийм нийгэм л хамгийн сайн нийгэм, хөгжлийн өндөр төвшинд гарч чадсан нийгэм байдаг юм.¹

Иймд бид өнөөдөр зөвхөн хувь хүмүүсийг төдийгүй нийгмээ мөнгөний харилцаатай уялдуулан шинжилж дүн шинжилгээ өгөх хэрэгтэй байна. Манай нийгэмд мөнгөний харилцаа туйлын буруугаар явагдаж байна. Цөөн хэдхэн

¹ http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=dt_nso_2600_

хүний эрх ашигт нийцсэн 'мөнгөний богино эргэлт бий болчихоод банк санхүүгийн байгууллагууд нь тэрхүү богино эргэлтэнд зохицуулсан үйлчилгээг үзүүлээд байгаа нь нийгмийг нөмөрсөн ядуурлын нэгэн том эх булаг болчихоод байгаа нь нууц биш юм.

Хоёр . Мөнгө угаах гэмт хэрэг ба монгол улс дахь мөнгө хүүлэлт , шалтгаан нөхцөл

Мөнгө угаах гэдэг нь энгийн ухагдахуунаар гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлогын эх үүсвэрийг нуун далдлах, хууль ёсны мэт харагдуулж чөлөөтэй захиран зарцуулах зорилгоор бодит төрхийг өөрчилж, хувиргаж буй үйл явц юм. Мөнгө угаахыг олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд олон янзаар тодорхойлж ирсэн бөгөөд ихэнх улс орнууд НҮБ-ын ■‘Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг’ 2000 оны Палермогийн Конвенцид тодорхойлсон эрх зүйн тодорхойлолтыг хүлээн зөвшөөрдөг. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенцид тусгалаа олсон байдаг . Тухайлбал Тус Конвенцийн 6 дугаар зүйлд (Гэмт хэргийн улмаас олсон орлогыг гэмт хэрэгт тооцох) мөнгө угаахыг:

1) тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл эрх зүйн үндсэн зөрчлийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх;

2) тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эд хөрөнгийг эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах;

3) тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах;

4)Энэхүү зүйлд тусгагдсан аливаа гэмт үйлдлийг үйлдэхэд оролцсон, хуйвалдсан, завдсан, хамжсан, хатгасан, хөнгөвчилсөн, зөвлөсөн...”үйлдлийг гэмт хэрэгт тооцох хууль тогтоох болон бусад шаардлагатай арга хэмжээг авбал зохино...” гэж тодорхойлдог.

2017 оны 07 дугаар сарын 01-ны өдөр хүчин төгөлдөр болсон Эрүүгийн Хуулийн 18.6 дугаар зүйл мөнгө угаах гэмт хэргийг:

“...Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь

¹ С.Нарангэрэл “Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг”, УБ., 2015 он.
121 дэх тал.

<http://www.criminology.mn/post/188>

нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч. эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан: энэ хэргийг ЭХ-ийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж үйлдсэн; байнга тогтвортой үйлдсэн; албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн; зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн; хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн..гэж тус тус тодорхойлжээ.

Мөн мөнгө угаах гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг авч үзэхийн өмнө мөнгө угаах нь гэмт бүлэглэл, гэмт этгээдүүдэд ямар ач холбогдолтой байдгийг судалж үзэх нь зөв гэж үздэг. мөнгө угаах нь ашиг орлого хуримтлуулдаг гэмт үйл ажиллагаа явуулдаг гэмт бүлэглэл, гэмт этгээдийн дараах хэрэгцээ, шаардлагаас улбаатай байдагийг тодорхойлжээ . Үүнд:

-“Мөнгө угаах нь хууль сахиулах байгууллагуудад илчлэгдэх эрсдэлийг бууруулж шууд утгаараа эдийн засгийн үр шимийг нэмэгдүүлж гэмт хэрэг үйлдэж олсон бохир орлогыг хувиргаж эд хөрөнгө худалдан авах, хөрөнгө оруулалт хийх, гэмт үйл ажиллагааг тэлэх боломжтой болгодог.

-Гэмт хэргийн орлогыг хууль ёсны эдийн засгийн салбарт оруулах магадлалыг нэмэгдүүлдэг.

-Гэмт этгээд, гэмт бүлэглэлийн үйл ажиллагааны өнгөлөн далдлалт, нуугдмал байдлыг нэмэгдүүлдэг” зэрэг нь мөнгө хүүлэх үйл ажиллагаа буюу мөнгө угаах гэмт хэргийн нэг хэлбэр илрэх шинж нь байж болох юм.

Гэмт хэргийн улмаас олсон орлогоо угаах эдийн засаг, санхүүгийн салбарыг сонгохдоо тухайн салбарын ашигтай байдал, эрх баригчдын зүгээс тухайн салбарт тавьдаг хяналт, шалгалтын түвшинг зайлшгүй харгалздаг байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь ашиг, орлого хуримтлуулдаг бүх гэмт хэргийн өсөлтөд нөлөөлж гэмт этгээдүүдийн дархлааг нэмэгдүүлдэг болохыг хүлээн зөвшөөрдөг болсноос хойш мөнгө угаах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл судлалд ач холбогдол өгч эхэлдэг болжээ.

Манай улсын гадаад орчин сүүлийн 20 гаруй жилийн өмнөхөөс үндсээрээ өөрчлөгдлөө. Монгол Улс хоёр том гүрний дунд оршдог, далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдмал, буурай хөгжилтэй орон байсан бол эдүгээ дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутагт орших болж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний үлэмж нөөцтэй нь тодорхой болсон явдал олон улсын анхаарал. их гүрнүүд, үндэстэн дамнасан бизнесийн

бүлэглэлүүдийн геополитик, эдийн засгийн сонирхлыг татах болсон нь шинэ боломж, түүнчлэн шинэ эрсдлийг дагуулах болсны нэг жишээ бол мөнгө угаах гэмт явдал юм.

Монгол Улсын Засгийн газар эдийн засаг уналтад орсныг албан бусаар зарлачихсан. Ийнхүү хямралын үед амьдарч байгаа иргэд хоногийн хоолоо залгуулах гэж зовж байна. Үнэн чанартаа хаус, машин бодох ч хэрэггүй. Учир нь хэн нэгнээс мөнгө зээлээгүй хүн ч үгүй болсон. Энэ үед "Мөнгө хүүлэгч" л завшиж байна. Тэр бүү хэл япон, солонгос, хятад иргэд Монгол улсад мөнгө хүүлэх орон зайд нэвтэрч өдрийн зээл нэрээр худалдааны төв, захуудад мөнгө хүүлж байна.

Өнөөдрийн байдлаар, Монголд мөнгө угаасан гэх тодорхой нотлогдсон тохиолдол гараагүй байна. Гэсэн хэдий ч сонин хэвлэлээр буу, сум хилээр наймаалсан, хууль бусаар алт тээвэрлэсэн, Монгол хүнийг гадаадад худалдсан, авилга, хээл хахуулийн хэргийн шүүх хурал болсон, виз, байрны арилжаатай холбоотой луйвар, залилангийн тухай мэдээлэл их байна. Эдгээр нь зөвхөн илрүүлж байгаа гэмт хэргийн тухай мэдээлэл юм. Гэтэл илрүүлээгүй хэд байгааг бид мэдэхгүй. Тэд гэмт хэргээс олсон орлогынхоо зарим хэсгийг мэдээж банк, санхүүгийн системээр дамжуулан нуун далдлах, хувиргах, мөнгө хүүлэх, гадаад дотоодод шилжүүлэх оролдлого хийж байгаа нь тодорхой.

Эрүүгийн хууль зөрчсөн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй түүний улмаас буй болсон хор уршгийн хоорондын дотоод холбоо, хамаарлыг тусган илэрхийлэгч объектив орших категори бөгөөд түүний арга зүйн үндэс нь шалтгаан, үр дагаврын тухай гүн ухааны сургаал юм. Үйлдэл ба эс үйлдэл нь гэм хор бүхий хор уршигт зайлшгүй хүргэх нөхцөл болсон байдал нь шалтгаант холбоотой болохыг нотлон харуулдаг.

Энэ байдлаас харахад "Өдрийн зээл" буюу мөнгө хүүлэх үйл ажиллагааны санхүүжилт нь мөнгө угаах гэмт хэргийн объектив шинжийг агуулсан гэж үзэж болох юм.

Тухайлбал, худалдааны томоохон төвүүдэд гадны мөнгө хүүлэгчид иргэдэд 5-20 хувийн хүүтэй зээл олгож, иргэд их хэмжээгээр өрийн сүлжээнд оржээ. Уг нь Эрүүгийн цагдаагийн газрын Мөнгө хүүлэхтэй тэмцэх хэлтэс гэж байдаг ч өнөөдөр ийм хэргүүдэд хэн ч хариуцлага тооцдоггүй улмаас иргэд хохирсоор байна. Жишээлбэл "Нарантуул" олон улсын худалдааны төв, "Да Хүрээ" техникийн зах, хорооллын дэлгүүрүүдийн худалдагчид. "Хүчит Шонхор" захынхын гээд жижиглангууны наймаа эрхэлж байгаа хүмүүс бүгдээрээ "Өдрийн зээл"-д хамрагдаж, мөнгө хүүлэгчдийн золиос болсоор байна.

Мөнгө хүүлэгчдийн цаана Япон, Солонгос, Хятадын дунд гарын луйварчид байдаг бөгөөд өөрсдөө Монголд байдаггүй, монголчуудаар дамжуулан ББСБ байгуулж, зарим нь гар дээрээс зээл олгодог байна. Иргэд өндөр хүүтэй зээлээ төлж чадахгүйгээс ихээхэн хохирч байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд эд хөрөнгөсөө салсан 20 орчим хүн байгаа бол зарим нь ял сонсохдоо тулаад байгаа аж.

Тухайлбал, хоёр сая төгрөгийн зээл авсан иргэн Д өнөөдөр 4,7 сая төгрөг төлөх болчихсон, энэ мөнгөө төлж чадахааргүй болж өөр хэн нэгнээс дахин зээл авч урд хормойгоо хойд хормойгоороо нөхсөөр залилангийн хэргээр ял сонсох дээрээ тулжээ. Мөн нэг сая төгрөгийн зээл авсан хүн өдөр бүр 72 мянган төгрөг төлдөг гэх баримт ч байна. Энэ мэтээр мөнгө хүүлэгчид сард наймаачдаас 300-400 сая төгрөгийн цэвэр ашиг олж байгаа гэнэ.

Япон эзэнтэй гэх "ББСБ" хүү өндөр зээлээр иргэдийг хохироож байгааг зарим зээлдэгч хэлж байна. Мөнгө хүүлэгчид өдөрт 50-80 хүнд өдрийн зээл өгдөг, нэг худалдааны төв болон задгай зах дээр 10-20 орчим өдрийн зээл олгогч байдаг аж. Сүүлийн хоёр жилийн хугацаанд өдрийн зээлээс болж хохирсон иргэдийн тоо нэмэгдсээр байгаа ч хууль хяналтынхан юу ч хийхгүй байгааг МҮЭХ-оос шүүмжилж байв.

Өнөөдрийн байдлаар "Саруул" захаас 60 гаруй наймаачин гомдол гаргажээ. Хуулиар манайд мөнгө хүүлэлт, мөнгө угаалтыг зохицуулах эрх зүйн орчин байдаггүй, иргэд хоорондын харилцан тохиролцсоны үндсэн дээр явагддаг учраас тэр болгон хянах боломжгүй байдаг аж. Мөн өндөр хүүтэй зээл авах эрсдэлтэй гэдгийг иргэд мэддэг хэдий ч түүнээс өөр мөнгө хурдан олох боломжгүй учир бараагаа таслахгүй, амьжаргаагаа залгуулхын тулд ийнхүү зээл авдаг ажээ.

Бүх төрлийн зээл чөлөөлнө, мөнгө зээлүүлнэ гэсэн зар телевиз, радиогоор ихээр цацагдах болж иргэд ч энэ төрлийн үйлчилгээг сонирхож үйлчлүүлэх болоод удаж байна. Мөнгөний хэрэг яаралтай гарсан үед банкны үүдийг сахиж суулгүйгээр бүтээчих сайхан боломж. Мэдээж бүх зүйл хуулийн дагуу явагдаж таны гар дээр богинохон хугацаанд бэлэн мөнгө ирнэ.

Зээлэх мөнгөний хэмжээнээсээ шалтгаалаад хүү нь өөр өөр байдаг юм байна. Хоёр сая төгрөг зээлэх гэсэн юм хэзээ гаргаж өгөх боломжтой вэ, хүү нь хэдэн хувь байдгийг тодруулахад "200 мянгаас дээш хэмжээний мөнгө зээлэхэд хүү нь 10 хувь, харин түүнээс бага хэмжээгээр зээлбэл 20 хувийн хүү төлдөг. Бичиг баримттайгаа ирээд мөнгөө авч болно. Уулзаж байгаад нарийн ширийн юмаа ярилцъя" гэлээ.

Зээл олгохдоо гэрээгээ байгуулж гарын үсгээ зураад нотариатаар батлуулаад л болчихдог юм байна. Харин зээлээ буцаан төлөх хугацаа нь

долоогоос 14 хоногт багтдаг. Хугацаа хэтэрсэн долоо хоног тутамд дахин 10 хувийн хүү төлнө. Гэхдээ гэрээнд анх тусгасан хүүгийнхээ хэмжээгээр гэж ойлгож болно. Хэрэв та 20 хувийн хүүтэй мөнгө зээлсэн бол тэр хэмжээгээрээ хүүгээ давхар төлнө гэсэн үг. Хаана ч байхгүй шуурхай үйлчилгээ, өндөр хүүтэй гэрээний нөхцөл нэг иймэрхүү. Нэгэнт гэрээ байгуулчихсан, гарын үсгээ зурчихсан болохоор өнөөх айхтар гэрээний нөхцөлөөр багагүй хэмжээний мөнгийг зээлийн хүүд өгч таны гарт орсон шигээ богинохон хугацаанд мөнгө хүүлэгчийн гарт буцаад очно.

Зээл чөлөөлүүлэх үйлчилгээ ч дээрхтэй нэгэн адил. Зээлээ чөлөөлүүлснээр багахан ч гэсэн хугацаа хожиж байгаа хэрэг боловч эргээд илүү айхтар гэрээний нөхцөлтэй мөнгө хүүлэгчид өртэй болж байгаа хэрэг. Зээлээ төлж чадахгүй бол асар богино хугацаанд их хэмжээний өртэй болж барьцаа хөрөнгөө ч алдах эрсдэлтэй. Иймэрхүү янзаар мөнгө хүүлэгчид өр зээлийн дарамтад амьдардаг иргэдийн хөлс хүчийг мөлжиж хөлждөг. Хэрвээ та мөнгө хүүлэгчээс таван сая төгрөг зээллээ гэж үзэхэд долоо хоногийн дотор зөвхөн хүүндээ л 500 мянган төгрөг төлөх жишээтэй.

Хугацаандаа хүүгээ төлж чадахгүй бол хүү нь нэг дахин нэмэгдэнэ. Энэ мэтээр явсаар таны төлөх мөнгө улам л ихэсч ганцхан сарын дотор зөвхөн хүүндээ л гэхэд хоёр сая төгрөг төлнө. Үндсэн зээлээ нэмэхээр долоон сая төгрөг. Хэрвээ энэ хугацаанд зээлээ төлж чадахгүй бол гэрээнд заасан хугацааны дагуу таны барьцаа хөрөнгө мөнгө хүүлэгчийнх болно гэсэн үг. Энэ мэтээр өрийн дарамтад амьдрахыг хүсэхгүй иргэд сүүлдээ өнөөх барьцаа хөрөнгөө зараад ч болов өрийг нь төлөхөөс өөр аргагүй болж байна.

Олон хүн хувиараа хөдөлмөр эрхэлж лангуу түрээсэлж жижиг худалдаа эрхэлж байна. Тэд дотроо мөнгөний хүү, өрөө хэрхэн төлөх талаар айдастай явдаг болоод зохих байгууллагад нь мэдээлэл өгч чаддаггүйг албаны хүн хэлж байна. Түүгээр ч зогсохгүй зээлсэн мөнгөө төлж чадахгүй яваа наймаа эрхлэгчийн лангууг нь барьцаалж залилангийн хэрэгт гүтгэдэг бүлэг мөнгө хүүлэгчид бий болжээ. Манай улсад буй мөнгө хүүлэгчдийн дийлэнх нь солонгосчууд байна.

УИХ-аас 2015 онд Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Хуулийн шинэчлэлээр Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт “Мөнгө буюу эд хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгснөөр зээлийн гэрээ байгуулагдсанд тооцно”, гурав дахь хэсэг “Зээлийн гэрээ нь хариу төлбөргүй байна” гэсэн заалтыг нэмэлтээр оруулсан байдаг.

Мөн хуулийн 282 дугаар зүйл, 283 дугаар зүйлийн 283.2, 283.3, 283.4 дэх хэсгийг хүчингүй болгожээ. Өөрөөр хэлбэл, иргэд хоорондоо хүүтэй мөнгө зээлэхийг тус хуулиар хориглосон байна. Дээрх хууль батлагдсантай холбоотойгоор иргэд гар дээрээсээ хүүтэй мөнгө зээлэх нь хуулиар хориотой болсон байна.

Харин мөнгө хүүлэгчид банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан нэг өдрийн зээл гэх нэрийн дор мөнгө хүүлж байна. Япон, Солонгос, Хятадын мөнгө

хүүлэгчид монголчуудаар дамжуулан ББСБ байгуулж, зарим нь гар дээрээс зээл олгодог байна.

ДҮГНЭЛТ:

“Нэг өдрийн” буюу “хоногийн” зээл гэх санхүүгийн харилцаанд ойрын жилүүдэд ард иргэд, тэр дундаа жижиглэн худалдаа, үйлчилгээ эрхлэгчид олноороо холбогдож, багагүй хэмжээний хөрөнгө мөнгөөрөө хохирох асуудал анхаарал татаж байна.

Иргэний хуулийн 452 дугаар зүйл, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай болон холбогдох бусад хууль, тогтоомж, Хорооноос батлан мөрдүүлж байгаа журам, заавруудаар ББСБ-ууд өдөр тутмын төлөлт нэхэх, 100 хувиар нэмэгдүүлсэн хүү тооцох нөхцөл бүхий “нэг өдрийн зээл” олгох эрхгүй болно.

Хэрвээ ББСБ-ууд эдийн засгийн өнөөгийн хүндрэлтэй байдлыг далимдуулан ёс зүйгүй үйлдэл гаргаж, зохисгүй, хатуу нөхцөлтэй зээл олгон, зээлдэгчдэд өрийн болон хүүгийн дарамт үүсгэж, тэдний амьжиргааны эх үүсвэрийг барьцаалах үйл ажиллагаа явуулж байгаа бол үүнийг хууль бус гэж үзэх үндэслэлтэй тул зохих хууль, журмын дагуу шийдвэрлүүлэх ёстой.

Өөрөөр хэлбэл иргэд хоорондоо сайн дурын үндсэн дээр гэрээ байгуулж, зээлийн харилцаа үүсгэхийг Хорооны зохицуулалт болон хууль, журам, хяналт, шалгалтын арга хэрэгслүүдээр хязгаарлах боломжгүй боловч зээлийн гэрээг хэт нэг талыг барьж байгуулах нь тэгш зарчим, шударга ёс, эрх зүйн холбогдох хэм хэмжээгээр хориотой гэж дүгнэж байна.¹

Жишээлбэл Япон Улс нь бүс нутгийн санхүүгийн төв юм. Тус улс нь зохион байгуулалттай гэмт бүлэглэл (Якуза), Мексикийн хар тамхины бүлэглэл, бусад дотоодын болон гадаадын гэмт этгээдүүдийн өргөн хүрээний мөнгө угаах үйл ажиллагааны эрсдэлтэй нүүр тулсаар байна. Сүүлийн жилүүдэд Япон Улсад оршин суудаг Баруун Африкийн улс орнууд (Нигер, Гана г.м.)-ын иргэдийн үйлддэг олон төрлийн залилан, санхүүгийн гэмт хэргийн үзүүлэлт нэмэгдэж байна. Тус улсад ашиг орлого хуримтлуулдаг залилан, мөнгө хүүлэх (loan sharking), хулгай, хар тамхины наймаа, интернет орчин дахь хэрэглэгчийн банкны, зээлийн картны мэдээллийг вирус тараах эсхүл хууран мэхлэх замаар хулгайлах (phishing) гэмт хэргүүд зонхилж байгааг дүгнэж дээрх орны мөнгө хүүлэлтийн эсрэг авч хэрэгжүүлж байгаа туршлагыг өөрийн орны хөрсөнд тохируулан хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэв.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

-Мөнгө хүүлэлтийн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

¹ 2015 оны Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт

4. Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017 он